



“БЭРХ УУЛ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 2019/10

Улаанбаатар

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 61.1.2-р заалт болон “Бэрх уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монгол улсын Компанийн тухай хуулийн 61.1.2-т заасанчлан саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал, шаардалага гаргаж болно гэж заасаны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах саналыг нийт хувьцааны 51.82% буюу 9,878,708 ширхэг хувьцааг эзэмшигч Khanate Resource Holdings SARL компани тавьсан билээ. Үүний дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 10 сарын 18 өдөр хуралдуулахаар болсныг зарласугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 10 сарын 18-ны өдрийн 10 цагт UB INN hotel-ийн 4 давхарт 402 тоот-т зарлан хуралдуулсугай. Ээлжит бус хурлын зарыг тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө чөлөөлөх, ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь шинээр томилох асуудлыг хэлэлцүүлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 09 сарын 27 -ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2019 оны 09 сарын 11 -ны өдрөөр тогтоож, хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу мэдэгдсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2019 оны 09 сарын 18-ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас батлах тогтоолын төслийг гурвадугаар хавсралтаар баталсугай.
9. Санал авах саналын хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай. Компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан санал авах сүүлчийн өдрийг 2019 оны 10 сарын 17-ны өдөр байхаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргалагчаар А. Даваажав-г томилж, хурлыг зохион байгуулах, бэлтгэл хангаж ажиллахыг даалгасугай.
11. Тооллогын комиссын даргаар Э.Солонго-г, гишүүнээр Ч. Сарнай нарыг томилсугай.
12. Хурлын дэгийг тогтоолын тавдугаар хавсралтаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.Мянганбаяр



Б.МЯНГАНБАЯР